Байгууллагын нэр: “Улаанбаатар лифт” НӨҮГ

# АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ НИЙСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2022 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

| Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | № | 2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээ | Төсөв /мян. Төг/ | Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.1.1.төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | 1 | Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно. | - | Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байх. | Ажлын сул орон тоог байгууллагын www.ublift.ub.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод зарлан, сонгон шалгаруулж ажилд авч байна. 2022 онд зарын дагуу иргэдээс анкет болон ажилд орох хүсэлтээ ирүүлснээс Ахлах нягтлан бодогч-1, Жолооч-1, Хяналтын инженер-2 буюу нийт 4 ажилтныг тус тус сонгон шалгаруулж ажилд авсан.<br><br>Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс Ахлах нягтлан бодогчийн албан тушаалд З.Ариунтуяаг томилсон. | 100% |
| | 2 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны албан | - | Ажлын байранд тавигдах нийтлэг | Нийт 2021 оны А/18, 2020 оны А/08, 2019 оны А/22 дугаар тушаалаар 12 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулж, мөрдөн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна. | | шаардлагыг баталсан байх. | | |
| 4.1.1.2.нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх | 3 | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно. | - | Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байх. | Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилж байна. | 100% |
| 4.1.1.3.олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга, хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох | 4 | Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангана. | - | Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үр дүн, мэргэшлийн түвшинг үнэн зөв, шударгаар үнэлсэн байх. | Албан хаагчид хийж хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа сар, улирал жилийн хугацаатайгаар төлөвлөдөг ба гүйцэтгэл, үр дүнг ажилчдын шуурхай зөвлөгөөнөөр хэлэлцэн, дүгнэж ажилласан.<br>Ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын байрны тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээтэй уялдуулан улирал, хагас, бүтэн жилээр дүгнэсэн. | 100% |
| 4.1.1.7.нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх. | 5 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг мэдээллийн олон эх үүсвэрээр хүлээн авч шийдвэрлэнэ. | - | Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт, дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр | Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол ирээгүй байна.<br>Газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн, А/33 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийн даргаар Ерөнхий инженер М.Энхбат, гишүүнээр Хяналтын инженер Б.Байгаль, нарийн бичгийн даргаар Хүний нөөцийн мэргэжилтэн Ц.Өсөхжаргал нар томилогдсон бөгөөд хавсралтаар ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүн сайжирсан байх. | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, мөрдөж, зөрчил, дутагдалгүй ажиллаж байна. Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбар, http://ublift.ub.gov.mn/ цахим хуудсанд ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчилж байна. | |
| Хоёр.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.2.1.төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх. | 6 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал www.e-mongolia.mn системд холбоно. | - | Өөрт хэрэгтэй төрийн үйлчилгээг гэрээсээ эсвэл ажил дээрээсээ ямар ч цаг үед авч болох боломжийг бүрдүүлсэн байх. | "Албан хэрэг хөтлөлтийн систем, Байгууллагын архивын систем"-ээр тоон гарын үсгээр баталгаажсан цахим албан хэрэг хөтлөлтийг хэрэглээнд нэвтрүүлэн ашиглаж байна. | 100% |
| 4.1.2.6.өргөдөл, гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх | 7 | Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авах эх үүсвэрийг нэмэгдүүлж, шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулна. | - | Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх. | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын нэгдсэн систем erp.ulaanbaatar.mn нэгдсэн сайтаар дөрөвдүгээр улирлын байдлаар нийт 18 өргөдөл гомдол, хүсэлт ирсэн байна.<br>Иргэд аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанар, үр дүнг сайжруулж хуулийн хугацаанд нийслэлээс дэвшүүлсэн зорилтот түвшинд шийдвэрлэн ажилласан байна. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | (Манай байгууллага өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг 9 хоногт багтаан ажиллаж байна.) | |
| 4.1.2.7.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | 8 | Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлнэ. | - | Төрийн албан хаагчдын үйл ажиллагаанд иргэд үнэлгээ өгдөг болсон байх. | Байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээний судалгааг гэрээт ААНБ, СӨХ-доос авч үр дүнг нэгтгэн байгууллагын удирдлагад танилцуулан ажилласан. | 100% |
| Гурав.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр | | | | | | |
| 4.1.3.1.Улсын болон орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ил тод, нээлттэй, хариуцлагатай байх зарчмыг мөрдүүлэх | 9 | Гадаадын зээл тусламж, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт болон төсөл, хөтөлбөр, арга хэмжээ бүрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах орчныг бүрдүүлж, нээлттэй, ил тод болгох, мэдээллийг сайжруулна. | - | Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн явц, гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх. | Төсвийн хөрөнгийн зарцуулалтын дүн мэдээг сар бүр 24 удаа шилэн дансны http://www.shilendans.ub.gov.mn/home цахим хуудсанд бүртгэж үйл ажиллагаандаа шилэн дансны тухай хуулийг мөрдөн хэрэгжүүлж ажилласан.<br><br>2022 оны 02 дугаар сарын 10-ны өдөр http://city.audit.mn цахим хуудсанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шивж оруулсан. | 100% |
| 4.1.3.3.Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох | 10 | Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна. | - | Мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг хэвшүүлсэн байх. | | |

| | |
|---|---|
| Биелэлтийн дундаж хувь | 100% |

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДАРГА Д.ГАН-ЭРДЭНЭ

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ц.ӨСӨХЖАРГАЛ